



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 97

Номгон

“Отгонбулаг” ХХК-ний үйл ажиллагааг
дэмжиж, хувь эзэмших тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “е”, “ж” заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалт, 78 дугаар зүйлийн 78.2.3 дахь заалт, “Отгонбулаг” ХХК-ний 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 18/06/03 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Отгонбулаг” ХХК-ний эзэмшлийн 20 хувийг өгөх саналыг зохих хууль, тогтоомжийн дагуу судалж, үнэ төлбөргүйгээр шилжүүлж, цаашид хамтран ажиллахаар ирүүлсэн саналыг дэмжсүгэй.

2. Орон нутгийн өмчийн оролцооны хувь хэмжээ хариуцсан албан ёсны төлөөлөгчөөр “Баянхонгор Нью Майнинг” орон нутгийн өмчит ХХК-ийг томилсугай.

3. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

3.1. “Отгонбулаг” ХХК-ийг орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж болгон зохион байгуулж, ажлын хэсэг гаргаж хуулийн хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласугай.

3.2. Орон нутгийн өмчийн оролцоотой “Отгонбулаг” ХХК-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулах журам”-ын дагуу сонгон шалгаруулалтад оролцуулах, саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт уламжилсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018 (Au

0118053